

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр  
сарын 10-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр  
гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах  
ажлын төлөвлөгөө батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг, батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг Бичил санхүүгийн газарт даалгасугай.

3. Дээрх хууль, батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг төсөвт тусгуулах, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР  
ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2009 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр

№	Арга хэмжээ	Хариуцах нэгж	Хугацаа
1	Хуулийн хэрэгжилтийг хариуцах газар нэгжийн чиг үүргийг тодорхойлох	Хорооны хурлын шийдвэр	2009 оны 9 сарын дотор
2	Хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой ажлыг хэрхэн гүйцэтгэх талаарх Хорооны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод нэмэлт оруулах, холбогдох ажилтнуудын ажил үүргийн хуваарьт нэмж тусгах	Ажлын алба	2009.09.20-ны дотор
	Валютын улсын байцаагчийн эрх олгох ажлыг зохион байгуулах	ТГ	2009.09.25-ны дотор
3	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр журам гаргах, холбогдох журмуудад өөрчлөлт оруулах	БСГ	2009.10.15-ны дотор
4	Бараа ажил үйлчилгээг гадаад валютаар гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргах	БСГ	2009.10.15-ны дотор
5	Олон нийтэд сурталчлах - Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас болон мэдээллийн портал сайтууд дээр хууль, судалгаа, шалгалтын дүн, авсан арга хэмжээ зэргийг байршуулах  - Олон нийтийн телевиз, радио, өдөр тутмын сонин хэвлэлээр хуулийн талаарх мэдээллийг хүргэх  - Хуулийн талаарх зурагт хуудас хийж, худалдаа үйлчилгээний төвүүдэд тараах ажлыг олон нийтийн байгууллагууд, их сургуулиудтай хамтран гүйцэтгэх	ТГ БСГ  Ажлын алба  Ажлын алба	Тогтмол хийх  Тухай бүр  2009.10.20-ны дотор
6	Монголбанк, Сангийн яам, ҮТЕГ, Мэргэжлийн хяналтын газартай хамтран ажиллах, мэдээлэл солилцох	Ажлын алба	Тухай бүр
7	Аж ахуйн нэгж байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий төрийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудын холбоодод өөрийн зохицуулалтын байгууллагуудад тус хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах тухай албан тоот хүргүүлэх	Ажлын алба БСГ	2009.10.15-ны дотор

8	Хадгаламж, зээлийн хоршоодод гадаад валютаар хадгаламж авч, зээл олгож байгаа үйл ажиллагааг зогсоох тухай мэдэгдэж, үзлэг шалгалт хийх	БСГ	Тухай бүр
9	Нээлттэй утас ажиллуулах, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг бүртгэн, мэдээллийн дагуу шалгалт зохион байгуулж, холбогдох арга хэмжээг тухай бүр авах	ТГ БСГ Улсын байцаагчид	Байнга
10	Валютаар гүйлгээ хийж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад удирдамжийн дагуу хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах	БСГ Улсын байцаагчид	2009.10.15-ны дотор Тухай бүр
11	Газар дээрх шалгалтын зөрчлийн талаар холбогдох арга хэмжээг авч, дүнг олон нийтэд сурталчлах,	БСГ Улсын байцаагчид	2009.11.01-ний дотор Тухай бүр